



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨСВИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Б.ЧОЙЖИЛСҮРЭН ТАНАА

2020.05.04 № 1485
танай _____-ны № _____-т

Аудитын сэдвийн төсөл хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасны дагуу Үндэсний аудитын газрын 2021 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төслийг хүргүүлж байна.

Үндэсний аудитын газраас 2021 онд гүйцэтгэх аудитын сэдвийг сонгохдоо Төрийн аудитын тухай, Төсвийн тухай болон бусад хууль тогтоомж, төрийн аудитын байгууллагаас баримталж байгаа бодлогын хүрээнд аудит хийж дүгнэлт гарган, Улсын Их Хурал, Засгийн газарт бодлогын зөвлөмж хүргүүлэх шаардлагатай эрсдэлтэй асуудлуудыг сонгон авч, аудит хийхээр боловсруулсан болно.

Хавсралт ... хуудастай.



Д.ЗАНДАНБАТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН 2021 ОНД ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДВИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2020.04.29

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний аудитын газраас 2021 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөөг боловсруулан Төсвийн байнгын хорооны хуралдаанаар шийдвэрлүүлэхээр Та бүхэнд танилцуулж байна.

Үндэсний аудитын газраас 2021 онд Монгол Улсын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хүрээнд болон төрийн аудитын байгууллагын бодлогоор гүйцэтгэх аудитын нийт 30 сэдвийг төлөвлөснөөс хууль тогтоомжийн дагуу 22, төрийн аудитын бодлогоор гүйцэтгэх 6, мөн он дамжиж гүйцэтгэх 2 аудит байна.

Нэг. Хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх зарим аудитын хувьд:

1.1. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын дагуу улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд аудит хийж, дүгнэлт гаргах хүрээнд дараах томоохон концесс хамрагдана. Үүнд:

- “Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам барих”;
- “Дашинчилэн Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам барих”;
- “Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын “Шар тээг”-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам барих” гэх мэт.

1.2. Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын болон олборлолт /Доншен газрын тос (Монгол) ХХК, “Петрочайна дачин тамсаг Монгол” ХХК-ын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад хийх аудитын сэдвүүдийн хувьд 2020 оныг хамруулан аудитыг гүйцэтгэнэ.

1.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль 2021 онд болохтой холбоотойгоор сонгуулийн 4 аудитын сэдэв байна.

Хоёр. Төрийн аудитын байгууллагын бодлогоор болон он дамжиж гүйцэтгэх аудитын хувьд:

2.1. Төрийн аудитын байгууллагын бодлогоор дараах 6 аудитыг гүйцэтгэхээр төлөвлөсөн болно. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн;
- Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүн;

- Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд аудит хийх;
- Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө;
- Эрчим хүчний дамжуулалт, түгээлт, үнэ тарифын зохицуулалт, үр нөлөө;
- Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд хийх аудит.

2.2. Үндэсний аудитын газраас 2020-2021 онд дараах 2 аудитыг он дамжуулан гүйцэтгэхээр тусгасан болно. Үүнд:

- Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө, оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө;
- Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөө.

Үндэсний аудитын газраас 2021 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү?

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ**

2020 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

Аудитын сэдэв батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1. Үндэсний аудитын газрын 2021 онд гүйцэтгэх аудитын сэдвийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заасан аудитын сэдвийг үндэслэн Үндэсний аудитын газрын санхүүгийн болон хүний нөөцтэй уялдуулан аудитын төлөвлөгөөг боловсруулж, цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, шаардагдах зардлыг төсөвт тусгах, аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудитор /Д.Занданбат/-т үүрэг болгосугай.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН 2021 ОНД ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДЭВ

№	Аудитын сэдэв	Хамрах хүрээ	Улсын Их Хуралд хүргүүлэх хугацаа	Хэлэлцүүлэх Байнгын хорооны нэр
ХУУЛИЙН ДАГУУ ГҮЙЦЭТГЭХ АУДИТ				
1	Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх	төсвийн шууд захирагчид	-	-
2	Төсөл, хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланд аудит хийх	төсөл, хөтөлбөрүүд	-	-
3	Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийх	Засгийн газрын тусгай сангууд	-	-
4	Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх	төсвийн төвлөрүүлэн захирагчид	-	-
5	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийх	төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд	-	-
6	Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх	төсвийн ерөнхийлөн захирагчид	-	-
7	Сангийн Яамны 2020 оны санхүүгийн тайланд аудит хийх	Сангийн яам	-	-
8	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Сангийн Яам	2021.06.10	Байнгын хороод
9	Монгол Улсын 2020 оны Нэгдсэн төсвийн гүйцэтгэл	Сангийн яам	2021.06.10	Байнгын хороод
10	Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, төсөл хөтөлбөр, сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийх	бүх төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	-	-

11	Гүйцэтгэх ажиллагаанд зориулсан хөрөнгийн зарцуулалт	Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар	2021.07.01	Тусгай хяналтын дэд хороо
12	Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх	Сангийн яам	2021.10.16	Төсвийн байнгын хороо
13	Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг	Улсын төсвийн ерөнхийлөн захирагч	2021.06.15	Төсвийн байнгын хороо
14	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, төсвийн ерөнхийлөн захирагч	2021.05.01	Эдийн засгийн байнгын хороо
15	Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт	Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, гэрээлэгч талууд	2020.12.10	Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо
16	Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох	сонгуульд оролцох нэр дэвшигч	Сонгууль зохион байгуулах цаглаварт заасан хугацаанд	Сонгуулийн ерөнхий хороо
17	Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэхэд болон сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрт дүгнэлт гаргах	сонгуульд оролцох нэр дэвшигч	Сонгууль зохион байгуулах цаглаварт заасан хугацаанд	Сонгуулийн ерөнхий хороо
18	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нийтэд мэдээлэх	сонгуульд оролцох нэр дэвшигч	Сонгууль зохион байгуулах цаглаварт заасан хугацаанд	Сонгуулийн ерөнхий хороо
19	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлд аудит хийх	сонгуульд оролцох нэр дэвшигч	Сонгууль зохион байгуулах цаглаварт заасан хугацаанд	Сонгуулийн ерөнхий хороо
20	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт,	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, хайгуулын үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж	2021.12.10	Эдийн засгийн байнгын хороо

	Борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит			
21	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2020 онд олборлолтын үйл ажиллагаа явуулсан "Доншен газрын тос (Монгол)" ХХК-ийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитад	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, "Доншен газрын тос (Монгол)" ХХК	2021.12.10	Эдийн засгийн байнгын хороо
22	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2020 онд олборлолтын үйл ажиллагаа явуулсан "Петрочайна дачин тамсаг Монгол" ХХК-ийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, "Петрочайна дачин тамсаг Монгол" ХХК	2021.12.10	Эдийн засгийн байнгын хороо
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН БОДЛОГООР ГҮЙЦЭТГЭХ АУДИТ				
23	Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүн	Засгийн газар, Сангийн яам, холбогдох бусад байгууллага	2021.06.30	Эдийн засгийн байнгын хороо
24	Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт	Засгийн газар, Үндэсний хөгжлийн газар, холбогдох бусад байгууллага	2021.12.30	Эдийн засгийн байнгын хороо
25	Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд хийх аудит	Сангийн яам, холбогдох бусад байгууллагууд	2021.12.20	Төсвийн байнгын хороо
26	Эрчим хүчний дамжуулалт, түгээлт, үнэ тарифын зохицуулалт, үр нөлөө	Эрчим хүчний яам, "Диспетчерийн үндэсний төв" ХХК	2021.12.30	Эдийн засгийн байнгын хороо
27	Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн	Засгийн газар, Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн Ерөнхий газар, бусад холбогдох байгууллага	2021.12.25	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо
28	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө	Засгийн газар, Эрүүл мэндийн яам, бусад холбогдох байгууллага	2021.12.25	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо

ОН ДАМЖИЖ ГҮЙЦЭТГЭХ АУДИТ

29	Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө, оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө	Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, "Эрдэнэс МГЛ" ХХК, "Эрдэнэс Оюутолгой" ХХК, "Оюутолгой" ХХК	2021.12.30	Эдийн засгийн байнгын хороо
30	Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөө	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, аймаг, нийслэлийн ЗДТГ	2021.04.15	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо

--- хХх ---